




Зуун зуунд  
Нугаршгүй чанар

# 2021 оны жилийн эцсийн тайлан



2022 оны 03-р сарын 18



# Үйл ажиллагааны тайлан

## Агуулга



Зуун зуунд  
Нугаршгүй чанар

- Үйл ажиллагааны тайлан
  - Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, тайлан
  - Бүтэц орон тооны төлөвлөгөөний биелэлт, тайлан
- Борлуулалт, хангамжийн тайлан
  - Борлуулалтын төлөвлөгөөний биелэлт, тайлан
  - ТЭМ-ын худалдан авалт зарцуулалтын тайлан
- Санхүүгийн тайлан
  - Орлого үр дүнгийн тайлан
  - Зардлын тайлан
  - Зээл санхүүжилтийн тайлан
  - Бусад санхүүгийн тайлан
- Хувьцааны арилжааны тайлан
- Бартертын борлуулалтын тайлан


# Үйл ажиллагааны тайлан




Зуун зуунд  
Нугаршгүй чанар

- 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 56 ажилтантайгаар M0-M500 хүртэлх маркын бетон зуурмаг мөн тусгай зориулалтын ус нэвтэрдэггүй бетон зуурмаг үйлдвэрлэж, зах зээлд 61,923.6 м.куб бетон зуурмаг борлуулж, 14,0 тэрбум төгрөгийн борлуулалт хийж ажилласан байна.
- Энэ нь өмнөх жилтэй харьцуулахад ашиг **546%**-аар өссөн үзүүлэлттэй байна. 2020 онтой харьцуулахад бетон зуурмагийн борлуулалт 51%-аар, түлш борлуулалт 375%, помпны борлуулалт 1429%-аар, түрээсийн борлуулалт 4%-аар өссөн бол байрны борлуулалт 11%-аар буурсан байна.
- Борлуулалтын бодлогын хувьд бид 40% бэлэн мөнгө 60% бартер гэсэн хувийн ихэвчлэн барьж ажиллаа.
- 2021 онд ковидын нөхцөл байдлаас шалтгаалж ажил бага гарсан. Гэхдээ 11, 12 сард үйлдвэр зогсоогүй ажилласан.

Нийт борлуулалтын хэмжээ (м.куб)



Нийт борлуулалтын орлого (сая.төг)




# Үйл ажиллагааны тайлан



Зуун зуунд  
Нугаршгүй чанар

- Цэвэр ашиг нь өмнөх жилтэй харьцуулахад ашиг **546%**-аар өссөн үзүүлэлттэй байна.
- Бүтэц орон тооны хувьд сүүлийн 5 жил тогтмол ижил орон тоогоор ажиллаж байна.
- 2021 онд ашигт ажиллагааг нэмэгдүүлэхийн тулд зардлыг аль болох бага түвшинд байх зорилготой ажилласан.
- Бүтэц орон тооны хувьд мөн хүн



Нийт ажилчдын тоо (хүн)



# Үйл ажиллагааны тайлан




Зуун зуунд  
Нугаршгүй чанар

## Орон тоо

Нийт ажилчдын тоог 5 жилээр харьцуулж үзвэл алба хэлтсүүд тогтмол хүнтэй ажиллаж байгаа. Учир нь борлуулалт бага байгаа тул хүн нэмэх шаардлага бага гарч байна.

Хэдийгээр ажилчдын тоо харьцангуй тогтмол ч АТТА-ын ажилчид оролт, гаралт ихтэй байдаг.

## Нийт ажилчдын тоо /2017-2021 он/



# Үйл ажиллагааны тайлан



Зуун зуунд  
Нугаршгүй чанар

## 2021 оны онцлох ажлууд:

- Сул зогсдог өвлийн саруудад ажил гаргаж өвөл зогсохгүй ажилладаг боллоо. /1, 2, 3, 11, 12 сар/
- Өвлийн саруудад 15,000 м.куб орчим зуурмаг гаргасан.
- Оюу Толгой ХХК-ийн бетон зуурмагийн төсөлд бүтэн багаар ажиллаж дуусгасан.
- Өндөр маркын бетоны тохирлын гэрчилгээ авсан.
- Үйлдвэрийн хашааны олон жилийн хог хаягдлыг бүрэн зайлуулж дуусгасан.
- Ковидын үед халдвар хамгааллын дэглэмийг сайн барьж зогсолтгүй ажилласан.
- Ковидын түргэвчилсэн тестийг тогтмол авч ажилчдын эрүүл мэндэд анхаарч ажиллаа. Ажилчдыг халдвар хамгааллын хэрэгсэл, дархлаа дэмжих бүтээгдэхүүн, эм хангамжаар хангаж ажилласан.
- Борлуулалтын хувьд үйл ажиллагааг тасалдалгүй явуулах зорилгоор бэлэн бартер, бэлэн мөнгө төлөх нөхцөлтэй ажлуудыг илүү авч ажилласан.

# Үйл ажиллагааны тайлан



Зуун зуунд  
Нугаршгүй чанар

## 2021 оны онцлох ажлууд:

- Үнсний элеватор ашиглалтанд оруулж цементийн орцыг 5-10% хэмнэлт хийлээ.

Түүхий эд материал	Хэмжээ /тн/	Нэгж үнэ	Нийт үнэ
Үнс	373.2	34,500	12,874,020
Цементийн хэмнэлт	373.2	190,000	70,900,400
Хэмнэлт			<b>58,026,380</b>

- 2021 оны 5-9 сарын хооронд үнстэй зуурж 58 сая төгрөгийн хэмнэлт хийсэн байна.

# Үйл ажиллагааны тайлан



Зуун зуунд  
Нугаршгүй чанар

## 2021 оны онцлох ажлууд:

- ТЭМ-ыг тасалдалгүй хангах зорилгоор
- 0-5, 5-10, 10-20мм хайрга дайрганы үндсэн томоохон 10 харилцагчтай тогтвортой гэрээ байгуулан ажиллаа.
- Цементийн хувьд том 3 үйлдвэртэй хамтын ажиллагаатай байна.
- Нэмэлт бодис дээр хуучны томоохон 3 харилцагчтай хамтын ажиллагаатай байсан.
- Түлш: Бэлэн мөнгөний урсгалыг сайжруулах тал дээр илүү анхаарч 11 сар хүртэл бартерын түлш худалдан авалтыг илүү анхаарч ажиллаа.



# Борлуулалтын тайлан



Зуун зуунд  
Нугаршгүй чанар


## Төлөвлөгөө

Үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээг нэмэгдүүлж ашигт ажиллагааг сайжруулах

83%

## Гүйцэтгэл

Төлөвлөгөөний гүйцэтгэл 83% буюу төлөвлөгөөнд хүрээгүй.



# Борлуулалтын тайлан



Зуун зуунд  
Нугаршгүй чанар

Сар	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	Нийт
2021 он гүйцэтгэл	284.5	322.0	3,041.5	3,141.5	4,245.8	11,371.3	8,489.0	6,387.0	6,015.0	5,655.0	7,103.0	5,868.0	61,923.6
Төлөвлөгөө	750	1,125	3,000	7,800	9,000	10,500	9,750	10,125	10,875	7,575	3,000	1,500	75,000
Гүйцэтгэлийн хувь	38%	29%	101%	40%	47%	108%	87%	63%	55%	75%	237%	391%	83%


- Борлуулалтын гүйцэтгэлийн хувиас харахад:
- 6, 11, 12-р саруудад борлуултын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн.
- 3-р сард төлөвлөгөөгөө биелүүлсэн
- 1, 2, 4, 5, 7, 8, 9, 10-р саруудад төлөвлөгөөндөө хүрч чадаагүй байна.
- Хамгийн гол ажлын саруудад төлөвлөгөөндөө хүрч чадаагүй байгаа нь ажил эхлэх үед яригдаж байсан ажлууд цуцлагдаж гэрээ хийж чадаагүй байна гэж дүгнэж байна.

# Борлуулалтын тайлан

## өмнөх онтой харьцуулсан тайлан



Зуун зуунд  
Нугаршгүй чанар



Борлуулалтын хэмжээг 2020 болон 2021 оноор сар сараар харьцуулж харвал 2021 онд өмнөх оноос 4, 5, 9,10-р саруудад буурсан байна. Харин 1, 2, 3, 6, 7, 8, 11, 12-р саруудад илүү борлуулалт гаргасан байна.


Борлуулалт өссөн шалтгаан нь өвлийн сул зогсолтын саруудад ажил гарсан нь илүү өсөх шалтгаан болжээ.

2021 онд онцлох томоохон төслийн борлуулалт хараахан хийж чадаагүй ч Оюу Толгойн бетоны тендерт оролцсон нь илүү туршлага мэдлэг олж авахад үүрэг гүйцэтгэсэн.

# Борлуулалтын тайлан



Зуун зуунд  
Нугаршгүй чанар



Борлуулалтын бүтцийг 2 жилээр харьцуулж харвал 2021 онд M250, M350, M400 маркын бетон нийт борлуулалтын 77%-ийг бүрдүүлж байгаа бол 2020 онд M250, M300, M350 маркын бетонууд 82%-ийг бүрдүүлж байсан байна.


Борлуулалтын графикаас харахад жил бүр бетоны марк өсч байна. Энэ нь барилгын давхар өндөр болж буйтай холбоотой.

# Борлуулалтын тайлан



Зуун зуунд  
Нугаршгүй чанар

## ХАРИЛЦАГЧДЫН ТОО СҮҮЛИЙН 3 ЖИЛЭЭР



Харилцагчдын тоон үзүүлэлтийг тухайн сар бүрд давтагдах тоогоор авч үзлээ.

Хэдийгээр 2019 онд өвлийн саруудад ажлаагүй нийт харилцагчдын тоо 249 харин 2021 онд 243 2020 онд 184 байна.

Эндээс харахад 2019 онд ажлын саруудад олон харилцагчидтай илүү их ажил хийж байсан байна.

Тиймээс гол сарууд дээр олон харилцагчидтай гэрээгээ баталгаажуулах нь чухал байна.

# Борлуулалтын тайлан

## 2021 оны томоохон харилцагчид



Зуун зуунд  
Нугаршгүй чанар

МД Прожект ХХК – ХУД Шүншиг вилла Орон сууцны төсөл – 8,227 м.куб



Эн Си Ди групп ХХК – ХУД Арцатын аманд Каса Да Винчи хаус хотхон

Гарден сити-2 хотхон – 5,484 м.куб



Вайт мүүд лайт ХХК, Эх газрын жигүүр ХХК-ууд – БЗД-т  
Дэвжих Өргөө хороолол – 6,470 м.куб



# Борлуулалтын тайлан

## 2021 оны томоохон харилцагчид



Зуун зуунд  
Нугаршгүй чанар

Инэл ХХК – БЗД Өгөөмөр захын хажууд Их Мандал хотхон – 3,257 м.куб



Түшиг Даймонд ХХК – ХУД хаус хотхон – 3,162 м.куб



# ТЭМ-ийн тайлан



Зуун зуунд  
Нугаршгүй чанар

Д/д	Материалын нэр	Хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ	Худалдан авалт		Бартерын хувь
					Бартер	Бэлэн мөнгө	
1	05 элс м.куб	49,163	26,500	1,306,290,624	1,249,183,479	57,107,145	96%
2	10-20 дайрга м.куб	7,115	24,000	176,647,290	144,043,244	32,604,046	82%
3	10-20 хайрга м.куб	25,197	21,000	529,138,986	418,197,919	110,941,067	79%
4	Задгай цемент тн	24,191	200,000	4,838,155,600	451,843,113	4,386,312,487	9%
5	Үнс тн	373	34500	12,874,020		12,874,020	0%
6	Өвлийн нэмэлт кг	35,000	3,100	112,100,000	112,100,000		100%
7	Зуны нэмэлт кг	284,151	2,870	753,498,548	753,498,548		100%
8	Түлш литр	295,541	2,638.87	779,893,500	624,744,409	155,149,091	80%
	<b>Нийт</b>			<b>8,508,598,568</b>	<b>3,753,610,712</b>	<b>4,754,987,856</b>	<b>44%</b>



# Санхүүгийн тайлан



Зуун зуунд  
Нугаршгүй чанар

## ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

- Орлого үр дүнгийн тайлангаас харвал борлуулалтын орлого өмнөх жилээс 37%-аар өссөн ба үүнийг дагаад борлуулсан бүтээгдэхүүний өртөг 29%-аар өсч нийт ашиг мөн 81%-аар өссөн байна. Харин зардлын хувьд үйл ажиллагааны зардал 21%-аар өсч, үйл ажиллагааны ашиг 779%-аар, зээлийн хүүгийн зардал 536%-аар өсч, элэгдлийн зардал 14%-аар буурсан сайн үзүүлэлттэй байна. Тайлант хугацааны цэвэр ашиг өмнөх оноос 546% өсч -614 сая төгрөгийн алдагдалтай байсан үр дүн 138 саяын ашигтай болж ашигт ажиллагаа сайжирсан.
- Тайлангийн шинжилгээнээс харахад нийт ашгийн маржин өмнөх оноос 6%-аар, үйл ажиллагааны ашгийн маржин 8%-аар, Цэвэр ашгийн маржин 7%-аар өссөн үзүүлэлт гарсан байна.

Орлого үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/

Он	2018	2019	2020	2021	Төсөв	ӨОМҮ	ТГХ
Борлуулалтын орлого	9,188	13,518	10,251	14,000.2	12,821	137%	109%
ББӨ	6,304	10,366	8,781	11,344.5	9,101	129%	125%
Нийт ашиг	2,884	3,152	1,470	2,655.7	3,720	181%	72%
Үйл ажиллагааны зардал	1,617	2,101	1,589	1,728.5	2,065	121%	107%
Үйл ажиллагааны ашиг	1,267	1,051	-119	927.1	1,655	779%	179%
Элэгдлийн зардал	527	410	400	342.9	473	86%	138%
Зээлийн хүүгийн зардал	687	611	71	380.8	405	536%	106%
Татварын өмнөх ашиг	53	30	-590	203.4	777	-34%	382%
Ү/а-ны бус орлого	119	103	-21	-49.9	-37	238%	74%
Орлогын татвар	17.2	13	3	15.3	81	512%	530%
Цэвэр ашиг/алдагдал	155	120	-614	138.1	658	546%	477%
Нийт ашгийн маржин	31%	23%	14%	20%	29%	6%	9%
Үйл ажиллагааны ашгийн маржин	14%	8%	-1%	7%	13%	8%	6%
Цэвэр ашгийн маржин	2%	1%	-6%	1%	5%	7%	4%
ЕБИТДА маржин	1%	0%	-6%	1%	6%	7%	5%

# Санхүүгийн тайлан



Зуун зуунд  
Нугаршгүй чанар

## ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

- Орлого үр дүнгийн тайлангаас харвал Борлуулалтын орлого орлого 37%-аар өссөн ба бетоны борлуулалт 51%-аар өссөн. Энэ нь тоо хэмжээ өссөн болон үнийн өсөлттэй холбоотой.
- Мөн помпы борлуулалт тоо хэмжээ нэмэгдсэн болон үйл ажиллагаатай уялдан өссөн.
- ТЭМ-ийн тээвэртэй холбоотойгоор түлшний борлуулалт өсч байгаа.
- Харин орон сууц борлуулалтын сүүлийн жилүүдэд орлого үр дүнгийн тайланд тусгагддаг болсон. Учир иргэн болон ААН-үүд бартерын орон сууц борлуулалттай холбоотойгоор НӨАТ болон ибаримт өгдөг болсоноор заваа борлуулалтаар тусгах шаардлага гарч байгаа.

### Орлого үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	Төсөв	ӨОМҮ	ТГХ
Бетон зуурмагийн орлого	8,418,063	11,401,180	7,508,283	11,335,958	12,435,493	151%	91%
Помпы орлого	261,982	153,425	11,224	171,637	181,260	1529%	95%
Түрээсийн орлого	142,703	127,500	111,063	26,913		24% #DIV/0!	
Түлш борлуулалтын орлого	359,694	440,829	35,288	167,691	204,200	475%	82%
Байр борлуулалтын орлого	5,566	1,395,474	2,585,283	2,302,623		89% #DIV/0!	
Нийт борлуулалтын орлого	9,188,009	13,518,408	10,251,141	14,004,822	12,820,953	137%	109%

# Санхүүгийн тайлан

## ББӨ-ийн тайлан



Зуун зуунд  
Нугаршгүй чанар

### ББӨ-ийн тайлан

- ББӨ-ийн тайлангаас харахад 2021 онд өмнөх 2 оноос өртөг нэмэгдсэн байна. Шалтгаан нь:
- 1. 2020 онтой харьцуулахад тоо хэмжээ 50%-аар өссөн учир өртөг өссөн. Харин 2019 онтой харьцуулахад тоо хэмжээ бага байхад өртөг 8%-аар өссөн. Энэ нь сүүлийн 2 жил ковидын нөлөөгөөр материалын үнэ нэмэгдсэнтэй холбоотой юм.
- Үүнд: 2019 онд цемент 165,000 төгрөг байсан бол 2021 онд 205,000 төгрөг болж өссөн, мөн химийн нэмэлт хил гааль хаалттай, тээврийн зардал өссөн холбоотойгоор 1 тонн тутам нь 2,3 саяас 2,8 сая болж өссөн.

#### ББӨ-ийн тайлан /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2019 он	2020 он	2021 он	2021/2020	2021/2019
<b>ББӨ</b>	<b>10,366,181</b>	<b>8,780,700</b>	<b>11,344,530</b>	<b>127%</b>	<b>108%</b>
Материалын зардал	7,687,117	5,088,107	7,983,962	157%	104%
Түлш шатахууны өртөг	420,965	33,326	160,982	483%	38%
Түрээсийн өртөг			21,528		
Байрны өртөг	1,399,930	2,835,188	2,411,058	85%	172%
Шууд хөдөлмөрийн зардал	169,168	164,833	119,082	72%	70%
ҮНЗ	424,348	477,184	413,773	87%	98%
Элэгдлийн зардал	264,652	182,062	234,145	129%	88%

# Санхүүгийн тайлан

## ББӨ-ийн тайлан



Зуун зуунд  
Нугаршгүй чанар

### ББӨ-ийн тайлан

- Өртөгийн харьцуулалтыг харвал 1 м.куб бетонд материалын зардал 2020, 2021 онд 2019 онтой харьцуулахад 30%-аар өссөн байна. Энэ нь дээр дурьдсанчлан цементийн үнэ 24%-аар, нэмэлтийн үнэ 22%-аар бусад материалуудын 5-10%-ийн үнийн өсөлттэй холбоотой байна.
- Компанийн хувьд өртгийг бага байлгах тал дээр илүү анхаарч ажиллаж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд бетоны орцод өөрчлөлт ороогүй. 2021 онд өртөг бууруулах зорилгоор үйлдвэрлэлийн нөхцөлд үнсийг хэрэглэж байна.
- Үнс нь цементийн орцыг 5-10% буулгаж байгаа бөгөөд үнийн хувьд цементээс 5,5 дахин бага юм.

### 1 м.куб-ын өртөгий нхарьцуулалт

Үзүүлэлт	2019 он	2020 он	2021 он	2019 он	2020 он	2021 он
Тоо хэмжээ	80,445.17	42,591.50	61,923.60	1 куб бетоны өртөг		
ББӨ	8,545,286	5,912,186	8,750,962	106,225	138,811	141,319
Материалын зардал	7,687,117	5,088,107	7,983,962	95,557	119,463	128,932
Шууд хөдөлмөрийн зардал	169,168	164,833	119,082	2,103	3,870	1,923
ҮНЗ	424,348	477,184	413,773	5,275	11,204	6,682
Элэгдлийн зардал	264,652	182,062	234,145	3,290	4,275	3,781

# Санхүүгийн тайлан



Зуун зуунд  
Нугаршгүй чанар

## Үйл ажиллагааны зардлын задаргаа

Үйл ажиллагааны зардлыг өмнөх онтой харьцуулж харвал 19%-аар өссөн байна. Задаргааг харвал НДШ-ийн зардал 156%-аар өссөн ба энэ хөнгөлөлт дууссантай холбоотой. Мөн түлшний зардал 109%-аар өссөн нь үнэ 2 дахин нэмэгдсэнтэй холбоотой байна. ХАБ-ийн зардал 5 дахи нөссөн нь ковидтой холбоотой тест, хамгаалах хэрэгсэл, ариутгал халдваргүйжүүлэлт гэх мэт зардлуудаас үүдэлтэй.

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	Төсөв	2021/2020	ТГХ
<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>2,830</b>	<b>3,122</b>	<b>2,060</b>	<b>2,452</b>	<b>2,943</b>	<b>119%</b>	<b>83%</b>
Цалин, нэмэгдэл, урамшуулал	549.0	787.0	882.7	863.5	826.0	98%	112%
НДШ	80.5	124.7	43.7	111.6	107.4	256%	35%
Түлш, унаа	532.7	505.2	251.8	332.7	443.0	132%	75%
Гар утас, шуудан холбоо	18.2	32.6	34.8	47.5	26.2	136%	107%
Томилолтын зардал	15.7	15.0	5.8	13.6	20.4	234%	39%
Борлуулалтын зардал	125.4	162.3	35.8	30.7	59.5	86%	22%
Хөдөлмөр хамгаалал	1.6	13.3	1.8	11.8	38.7	644%	14%
Хангамжийн материалын зардал	4.4	13.2	22.8	7.5	18.5	33%	173%
Түрээсийн зардал	18.2	19.5	3.7	8.1	2.0	220%	19%
Сэлбэг, хэрэгслийн зардал	128.1	201.5	178.8	99.0	198.3	55%	89%
ТХ-ийн даатгалын зардал	6.5	8.3	5.9	8.7	12.0	148%	
ТХ-ийн оношлогоо, түрээс г.м зардал	25.3	31.8	7.2	8.2	11.4	114%	23%
Элэгдлийн зардал	526.9	409.8	400.4	342.9	472.9	86%	98%
Гэрээт ажил	54.8	90.7	51.8	84.3	28.8	163%	57%
Хүнсний зардал	1.6	0.9	0.2	2.0	0.0	864%	26%
ҮХХ, АТӨЯХ-н татвар	31.3	52.1	16.4	43.5	65.3	265%	31%
Зээлийн хүү, санхүүжилтын зардал	687.4	623.7	70.5	380.8	405.4	540%	11%
Байгаль орчин, үнэлгээний зардал	0.0	0.1	1.8	-	11.0	0%	
Зар сурталчилгааны зардал	9.9	19.1	9.4	16.1	18.0	171%	49%
Үйл ажиллагааны бусад зардал	12.2	11.0	34.7	39.7	178.4	114%	316%

# Санхүүгийн тайлан



Зуун зуунд  
Нугаршгүй чанар


## Баланс

Санхүү байдлын тайлангаас харахад 2021 онд эргэлтийн хөрөнгө 11%-аар өссөн ба эргэлтийн бус хөрөнгө 10%-аар буурсан байна. Энэ нь үндсэн хөрөнгийн элэгдлийн дүнтэй холбоотой ба зарим хөрөнгө элэгдлээрээ дууссан байна. Харин эргэлтийн хөрөнгө өссөн нь бараа материалын нөөцтэй холбоотой өссөн.

Өр төлбөрийн дүн 7%-аар өссөн нь зээлийн хуримтлагдсан хүү үүссэнтэй холбоотой.

Харин эздийн өмч 1 хувиар өссөн нь тайлант үеийн ашиг хуримтлагдсан алдагдалыг бага ч гэсэн бууруулж байна.

Үзүүлэлт	Санхүүгийн байдал /сая төгрөгөөр/					
	2017	2018	2019	2020	2021	
Эргэлтйн хөрөнгө	11,654	10,716	14,052	13,259	14,729	111%
Эргэлтийн бус хөрөнгө	8,659	7,029	6,436	5,798	5,245	90%
Нийт актив	20,313	17,745	20,489	19,058	19,974	105%
Өр төлбөр	13,733	11,952	12,053	11,672	12,479	107%
Эздийн өмч	6,580	5,793	8,436	7,385	7,495	101%
Нийт пассив	20,313	17,745	20,489	19,058	19,974	105%



# Санхүүгийн тайлангийн шинжилгээ



Зуун зуунд  
Нугаршгүй чанар

## 1. Төлбөрийн чадварын шинжилгээ

Төлбөрийн чадварын шинжилгээнээс харахад Ремикон ХК нь 2020 оноос 2021 онд илүү сайн үзүүлэлттэй байна.

Цэвэр эргэлтийн хөрөнгийн хувьд өмнөх онтой харьцуулахад ихээр нэмэгдсэн бөгөөд энэ нь борлуулалт нэмэгдэж өр төлбөр буурсны илрэл юм.

Эргэлтийг харьцааг харахад 1,9 байгаа нь 1 төгрөгийн өр төлбөрт 1,9 төгрөгийн эргэлтийн хөрөнгө ноогдож байгааг харуулж байна. Энэ харьцаа нь 2той ойр байвал илүү сайн гэж үздэг. Учир нь 1 төгрөгийн өр төлбөрийг эргэлтийн хөрөнгө нь нугалж байх тусам компани тасралтгүй үйл ажиллагаа явуулах боломжтой юм.

Мөн төлөгдөх хугацаа хэтэрсэн өр төлбөрийн хувийн жинг харахад 2021 онд өмнөх оноос буурсан бөгөөд энэ үзүүлэлт нь буурч байвал сайн гэж үздэг. Учир нь өр төлбөр буурч байна гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл өр төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулж төлөх дүнг бууруулж байгаа. Ингэснээрээ компанид өр төлбөр буурах нь эргэлтийн хөрөнгөд эерэг нөлөөтэй.

Санхүүгийн харьцаа		2020 он	2021 он
Төлбөрийн чадварын шинжилгээ	Цэвэр эргэлтийн хөрөнгө	9,094,110,232	9,251,255,355
	Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	2.6	1.9
	Түргэн хөрвөх хөрөнгө	10,303,654,735	10,447,771,015
	Эргэлтийн харьцаа	3.3	2.7
	Эргэлтийн хөрөнгийн хувийн жин	0.69	0.74
	Цэвэр эргэлтийн хөрөнгийн хувийн жин	0.69	0.63
	Төлөгдөх хугацаа хэтэрсэн өр төлбөрийн хувийн жин	0.65	0.56

# Санхүүгийн тайлангийн шинжилгээ



Зуун зуунд  
Нугаршгүй чанар

## 2. Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ

- Бие даах чадварын коэффициент нь 0,6 болон түүнээс дээш байх нь сайн үзүүлэлт болно. Энэ нь гадны эх үүсвэрээс хараат бусаар өөрийн санхүүжилтээр бие дааж үйл ажиллагаа явуулах чадварыг харуулна. Компанийн хувьд одоогийн нөхцөлд өөрийн эх үүсвэрээр үйл ажиллагаа явуулах нөөц боломж чадвар бага байгаа юм.
- Харин өр төлбөрийн хувийн жингийн үзүүлэлтээс харахад 1 төгрөгийн өр төлбөрт ноогдох эзний өмч нь 0,62 төгрөг байгаа нь өр төлбөр буурч байгаагийн илрэл юм. Ингэснээр компанийн хувьд урт болон богино хугацааны хөрөнгө оруулалтын шугамаар зээл авах боломж байгааг харуулж байна

Санхүүгийн харьцаа		2020 он	2021 он
Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ	Бие даах чадварын коэффициент	0.39	0.38
	Санхүүгийн хамаарлын коэффициент	2.57	2.67
	Зохицуулалтын коэффициент	1.24	1.23
	Өөрийн эргэлтийн хөрөнгө	9,094,110,232	9,251,255,355
	Өр төлбөрийн хувийн жин	0.61	0.62
	Урт хугацаат зээл болон эздийн өмчийн харьцаа	1.02	0.93
	Өр төлбөр ба эздийн өмчийн харьцаа	1.57	1.67



# Санхүүгийн тайлангийн шинжилгээ



Зуун зуунд  
Нугаршгүй чанар

## 3. Төлбөрийн хэтийн боломжийн үзүүлэлтүүд

- Хүү төлөх чадварын коэффициент нь нэг төгрөгийн хүүг төлөх татварын өмнөх ашгийн хэмжээг харуулдаг. Энэ үзүүлэлт нь нэгтэй тэнцүү байхад болно гэж үздэг. Харин компанийн хувьд 1,36 төгрөг байгаа нь зээлийн хүүг төлөх чадвартайг нотолж байна.

Санхүүгийн харьцаа		2020 он	2021 он
Төлбөрийн хэтийн боломжийн үзүүлэлтүүд	хүү төлөх чадвар	(7.73)	1.36
	Хүү ба үндсэн өрийг төлөх чавдар	(0.02)	0.12

# Санхүүгийн тайлангийн шинжилгээ



Зуун зуунд  
Нугаршгүй чанар

## 4. Эргэцийн шинжилгээ

Эргэцийн шинжилгээнээс харахад манай компанийн өр болон авлагын эргэц удаан харагдаж байна. Өөрөөр хэлбэл авлага 262 хоногтоо эргэж орж ирж байна. Бараа материал 88 хоногт, эргэлтийн хөрөнгө 379 өдөрт, өглөг 227 өдөрт эргэж байна.

Санхүүгийн харьцаа		2020 он	2021 он
Эргэцийн шинжилгээ	Авлагын эргэц /удаа/	1.02	1.37
	Авлагын эргэц /өдөр/	353	262
	Бараа материалын эргэц /удаа/	5	4
	Бараа материалын эргэц /өдөр/	73	88
	Эргэлтийн хөрөнгийн эргэц /удаа/	0.78	0.95
	Эргэлтийн хөрөнгийн эргэц /өдөр/	461	379
	Нийт хөрөнгийн эргэц	0.54	0.70
	Өглөгийн эргэц /удаа/	0.39	1.58
	Өглөгийн эргэц /өдөр/	920	227
	Үйлдвэрлэлийн циклийн хугацаа	425	350
Санхүүгийн циклийн хугацаа	(504)	122	

# Санхүүгийн тайлангийн шинжилгээ



Зуун зуунд  
Нугаршгүй чанар

## 5. Бүтээмжийн шинжилгээ

- Бүтээмжийн шинжилгээнээс харахад ажилчдын хөдөлмөрийн бүтээмж өндөр байна гэж харагдаж байна. Өөрөөр хэлбэл компанийн нэг ажилчин 241 сая төгрөгийн бүтээгдэхүүн бүтээж байна.
- Мөн үндсэн хөрөнгийн ачаалал сайн байгаа бөгөөд нэг төгрөгийн үндсэн хөрөнгө 4,18 төгрөгийн орлогыг бүтээж байна. Дараагийн нэг үзүүлэлт нь нэг төгрөгийн материалаар 5,16 төгрөгийн орлого олж байна.

Санхүүгийн харьцаа		2020 он	2021 он
Бүтээмжийн шинжилгээ	Хөдөлмөрийн бүтээмж	189,754,175	241,382,432
	Үндсэн хөрөнгийн ачаалал	2.62	4.18
	Материал өгөөмж	5.76	5.16
	Үндсэн хөрөнгийн хувийн жин	0.21	0.17
	ҮХ-ийн нийт дүнд үйлдвэрлэлийн зориулалттай ҮХ-ийн эзлэх хувийн жин	0.85	0.8
	ҮХ-ийн элэгдлийн коэффициент	0.10	0.11

# Санхүүгийн тайлангийн шинжилгээ



Зуун зуунд  
Нугаршгүй чанар

## 6. Ашигт ажиллагааны шинжилгээ

- Ашигт ажиллагааны шинжилгээнээс харахад нэг төгрөгийн борлуулалтаас 0,2 төгрөгийн ашиг олж байна. Өөрөөр хэлбэл нэгж бүтээгдэхүүнээс 20%-ийн нийт ашиг олж байна гэсэн үг.
- Хөрөнгийн ашигт ажиллагааг харахад нэг төгрөгийн хөрөнгөөр 0,01 төгрөгийн ашиг бүтээж байна. Мөн эздийн өмчиний ашигт ажиллагааг харахад нэг төгрөгийн эзний өмчөөр 0,02 төгрөгийн ашиг авч ирж байна.

Санхүүгийн харьцаа		2020 он	2021 он
Ашигт ажиллагааны шинжилгээ	Борлуулалтын ашигт ажиллагаа	0.14	0.20
	Өртгөөр тооцсон борлуулалтын ашигт ажиллагаа	0.16	0.26
	Хөрөнгийн ашигт ажиллагаа	(0.03)	0.01
	Эздийн өмчийн ашигт ажиллагаа	(0.08)	0.02

# Санхүүгийн тайлангийн шинжилгээ



Зуун зуунд  
Нугаршгүй чанар

## 7. Зах зээлийн идэвхижлийн шинжилгээ

- Зах зээлийн үнэ ба ашгийн харьцаа нь хувьцааны үнэ цэнийн өсөлтийг харуулах үзүүлэлт юм. Манай компанийн хувьд хувьцааны анхны үнэ 100 төгрөг байсан бол одоо 24 төгрөг болж унасан байна. Эндээс харахад компанийн хувьд салбарын байдлаас шалтгаалж ашигт ажиллагаа муудаж ханш унасан байна.

Санхүүгийн харьцаа		2020 он	2021 он
Зах зээлийн идэвхижлийн шинжилгээ	Зах зээлийн үнэ ба ашгийн харьцаа	(3.58)	13.67
	Зах зээлийн үнэ ба бүртгэлийн үнийн харьцаа	0.28	0.24
	Нэгж хувьцааны бүртгэлийн үнэ	100	100



**РЕМИКОН ХК**

**Баярлалаа**

*Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо, Сонсголон-181, РЕМИКОН ХК-ний үйлдвэрийн байр*

*Борлуулалт Маркетингийн алба: Утас: 777-7704, 88104190, 88109680*